


National
Datacenter



ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

Гар утасны фишинг ихээр нэмэгдэж байна


Lookout хэрэглэгчдийн судалгаанд гар утсаар дамжиж буй нийт фишинг URL –ын тэн хагас нь одоо ашиглагдаж байгаа аюулгүй байдлын системүүдийг өнгөрөн гарч байна гэж үзжээ. 2011 оноос хойш Lookout энэхүү гар утасны фишинг URL дарах хэмжээ жил бүр 85 хувиар нэмэгдэж байгааг ажиглажээ.



“Гар утасны төхөөрөмжүүд нь байгууллагуудын галт хана, сүлжээний аюулгүй байдлыг хангах уламжлалт сүлжээний аюулгүй байдлын шийдлүүдийн үр дүнг хязгаарлаж байна.” гэж Lookout –н стратегийн дарга Aaron Cockerill хэлжээ. Мөн тэрээр “И-мэйл, Олон нийтийн нийгмийн сүлжээний сайт, хувийн үйлчилгээ, хөдөлгөөнт төхөөрөмжүүд зэрэг нь илүүтэйгээр довтолгооны бай болдог ба эдгээр нь байгууллага аж ахуй нэгжийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.”

Фишинг халдлагууд нь хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр илүү үр дүнтэй байдаг учир нь нуугдсан цахим шуудангийн толгой хэсгүүд болон URL ууд нь цахим шуудангийн хаягууд болон цахим хуудаснуудыг мэхлэхэд илүү хялбар болгодог.

“Халдагчид SMS, болон одоогоор өргөн ашиглагдаж буй нийгмийн цахим сүлжээ болох WhatsApp, Facebook Messenger, Instagram зэрэг өндөр хөгжсөн платформын програмыг ашигладаг. Эдгээр довтолгооны шинэ чиг хандлагыг анзаардаггүй аюулгүй байдлын мэргэжилтнүүд өөрсдийн байгууллагыг эрсдэлтэй байдалд оруулдаг.” гэжээ.



Хөдөлгөөнт төхөөрөмжийн фишинг халдлагын 2018 оны онцлох үйл явдлууд

Мэдээг 2011 оноос хойш Lookout –р хамгаалагдсан 67 сая хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр дүгнэлт хийн гаргасан байна.

Хөдөлгөөнт төхөөрөмжийн фишингийн гарц нь ихэнх хэрэглэгчдээс хариу үзүүлсэн – Lookout хэрэглэгчийн 56 хувь нь хөдөлгөөнт төхөөрөмж дээрээ фишингээс хамгаалах системийг нэвтрэн гарсан фишинг URL хүлээн авч дарсан. Хөдөлгөөнт төхөөрөмжийн фишинг URL дээр дарсан хэрэглэгчид дунджаар жилд 6 удаа дарсан байна.

Хөдөлгөөнт төхөөрөмжийн фишинг ихсэж байна - 2011 оноос хойш Lookout хэрэглэгчид гар утасны фишинг URL дарах хэмжээ жилээс жилд 85 хувиар нэмэгдэж байна.

Халдлагын бүлгүүд хөдөлгөөнт төхөөрөмжийг ашиглах нь өндөр үр дүнтэй байгааг туршилтаар тогтоосон ба туршилтад орсон нэг байгууллагын ажилчдын 25 гаруй хувь нь өөрсдийн танилын дугаараас SMS –ээр ирсэн холбоос дээр дарсан байна.

ЭХ СУРВАЛЖ: <https://www.helpnetsecurity.com/2018/04/10/mobile-phishing-2018-report/>

2018.05.16